


МОНГОЛ УЛС
ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар A/190

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэхь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Соёл амралтын хүрээлэн, усны эх орчимд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2004-2011 онд тарьж ургуулсан таримал мод, сөөгийг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Галбадрах (Сум дундын ойн ангийн дарга)

Гишүүд: П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)


Б.Цэрэнсүгир (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ж.Миеэсүрэн (Сайнцагаан сумын ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

С.Цэрэн (Хот тохижилт үйлчилгээний газрын мэргэжилтэн)

Хоёр. Таримал мод, сөөгийг төрөл тус бүрээр нэг бүрчлэн тоолж Сайнцагаан сумын Хот тохижилт үйлчилгээний газарт 2020 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн дотор актаар хүлээлгэж өгөхийг ажлын хэсгийн ахлагч (Ц.Галбадрах)-д үүрэг болгосугай.

Гурав. Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, хамгаалалтын ажлын төсөв тооцоог гаргаж хариуцан ажиллахыг Хот тохижилт үйлчилгээний газрын дарга (Х.Анхбаяр)-д даалгасугай.



482010516